

DPUB 2 МЭДЭЭ

№ 04
2022 оны Дөрөвдүгээр сар

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулах хүсэлтэй “Алтан жолоо импекс” ХХК-тай уулзлаа

2022 оны 3-р сарын 31-ний өдөр төслийн ахлах мэргэжилтэн болон холбогдох ажилчид худалдаа, үйлчилгээ, хүнсний үйлдвэрлэл эрхэлдэг “Алтан жолоо импекс” ХХК-ийн захиргаа, хүний нөөцийн дарга Э.Цасанчимэгтэй уулзаж, ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой хэрэгжүүлж буй арга хэмжээ, байгууллагын бодлогын талаар тодрууллаа. Э.Цасанчимэг нь 3-р сарын 28-29-ний өдрүүдэд зохион байгуулсан “Ажлын байрны дадлагажуулагчийн талаарх анхан шатны семинар”-т оролцсон бөгөөд семинарын үеэр цаашид ХБИ-ийг ажиллуулах хүсэлтэй буйгаа бидэнд илэрхийлж байсан юм.



“Алтан Жолоо Импекс” ХХК Захиргаа, хүний нөөцийн дарга Э.Цасанчимэг даргатай хийсэн уулзалтын дараа

Э.Цасанчимэг “Манай байгууллага өмнө нь дотор эрхтний бэрхшээлтэй нэг хүнийг жолоочоор ажиллуулж байсан ч 3 сар болоод ажлаасаа гарчихсан. Одоогоор хөгжлийн бэрхшээлтэй ажилтан байхгүй ч нийгмийн хариуцлагынхаа хүрээнд ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, аль болох олон ХБИ ажиллуулах арга барилыг олж мэдэх зорилгоор DPUB2 төслийн зохион байгуулсан тус семинарт оролцсон. Нийт 117 ажилтантай ба цаашид орон тоогоо 150 хүргэхээр төлөвлөж байгаа бөгөөд хуульд заасан ажил олголтын 4%-ийн квотыг биелүүлэхийн тулд 6-аас дээш ХБИ ажиллуулах шаардлагатай” хэмээн ярьж байлаа.

“ХБИ-д хийлгүүлэх ажил байхгүй, ажлын чадвар бага, ажил олгогч болон удирдлагууд ХБИ ажиллуулах үнэ цэнийг тэр бүр мэдэдгүй, ажил хайж буй ХБИ-ийн мэдээллийг хаанаас авахаа мэдэхгүй” гэх мэт бусад байгууллагуудад тулгардаг нийтлэг асуудлууд байгааг олж мэдсэн юм. DPUB2 төсөл нь ААНБ-уудтай хийсэн уулзалтын үеэр дурдагдсан дээрх асуудлыг шийдвэрлэж, Монгол Улс дахь ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоог бэхжүүлэх зорилгоор үйл ажиллагаагаа явуулж байна. “Алтан жолоо импекс” ХХК-тай хамтран цаашид ХБИ-ийн сайн жишээг түгээн дэлгэрүүлэхийн тулд хичээнгүйлэн ажиллах болно.

2. ICT групп ХК-аар зочиллоо “Хөгжлийн бэрхшээлтэй ажиллах ажилчидтай харилцах харилцаагаа сайжруулах хүсэлтэй байна”



ICT групп Хүний нөөц хариуцсан ажилтан Г.Нандин-Эрдэнийн хамт (Баруун гар талаас хоёр дахь нь)

4-р сарын эхээр DPUB2 төслийн ахлах мэргэжилтэн болон холбогдох ажилчид мэдээлэл, харилцаа холбооны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг ICT групп ХК-аар зочиллоо. Тус группын хүний нөөцийн менежер Г.Нандин-Эрдэнэ биднийг халуун дулаанаар хүлээн авч, байгууллагынхаа ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой тулгарч буй асуудлын талаар илэн далангүй ярилцсан юм.

ICT групп нь 2011 онд байгуулагдсан бөгөөд Zeel, qPay, iMAP, iTOOLS, Eclinic зэрэг аппликейшн хөгжүүлэлтээрээ олон нийтэд танигдаж, “Зөв хүн, Зөв шийдлээр, Зөв ирээдүйг бүтээцгээе” гэсэн уриан дор салбартаа тэргүүлэх шинэлэг үйл ажиллагааг явуулсаар байна.

Одоогоор харааны бэрхшээлтэй Монгол залуу систем хөгжүүлэгчээр Япон улсаас буюу зайнаас ажилладаг ба Улаанбаатар хот дахь оффист хөдөлгөөний болон сонсголын бэрхшээлтэй хүмүүс ажиллаж байна.

DPUB2

Монгол Улс
дахь ХБИ-ийн
хөдөлмөр
эрхлэлтийг
дэмжих
тогтолцоог
бэхжүүлэх
төсөл

Үргэлжлэл 1-р нүүрт

Нөгөө талаар сонголын бэрхшээлтэй ажилтантайгаа харилцахад бэрхшээл тулгарч буйгаа ярьж байсан. Тиймээс ойлголт, харилцаагаа илүү сайжруулан асуудлыг шийдвэрлэх аргыг сурч мэдэхийн тулд DPUB 2 төслөөс зохион байгуулагдах сургалт, семинарт оролцох хүсэлтэй буйгаа илэрхийлж байлаа. ХБИ-ийг ажиллуулж буй ААНБ бүрт тулгарч буй нийтлэг асуудал энэ удаагийн уулзалтын үеэр ч дурдагдаж байлаа. Тиймээс DPUB2 төслийн зүгээс цаашид ICT групптэй хамтран ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажиллах хүсэлтэй байна.

3. ААНБ-уудад зориулсан 2 дахь удаагийн нөлөөллийн семинар

Монгол улс дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоог бэхжүүлэх DPUB2 төслийн зүгээс “ААНБ-уудад зориулсан 2 дахь удаагийн нөлөөллийн семинар”-ыг 2 дахь удаагаа зохион байгууллаа. Семинарыг нээж ХНХЯ-ны ХБИХХ-ийн дарга Б.Нарангарав үг хэлсний дараа төслийн ахлах зөвлөх Чиба төслийн үйл ажиллагааны талаар танилцууллаа.



ХНХЯ-ны ХБИХХ-ийн дарга Б.Нарангарав



DPUB2 төслийн ахлах зөвлөх Хисао Чиба

Уг семинарт ААНБ-уудын хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтан 30 хүн, ХБИ-ийн ТББ-уудын төлөөлөл 20 хүн ажиглагчаар оролцож байна. Үдээс өмнө Монгол Улсын хөдөлмөрийн хууль, ажлын байрны төлбөр, хяналтын тогтолцоо, Япон улсын ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн жишээ гэсэн сэдвийн хүрээнд төрийн байгууллагын холбогдох мэргэжилтнүүд лекц тавилаа.



Сургалтын үеэр



Сургалтын үеэр

Үдээс хойш Япон улсын “Мираиро” ХК-ын мэргэжилтэн багш нар “ХБИ-ийн ААНБ-д үзүүлэх үнэ цэнэ”-ийн талаар танилцуулсан бөгөөд семинарын төгсгөлд оролцогчид асуулт асууж, сургалт маш үр дүнтэй болж өнгөрлөө.

Маргааш “Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголтыг сайжруулах” гэсэн сэдвээр сургалт үргэлжлэх бөгөөд оролцогчид тэргэнцэр, цагаан таяг ашиглан практик дасгал ажил хийж үзэх юм. Сургалтад оролцож буй та бүхэнд амжилт хүсье.

 dpub.jica@gmail.com

 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 4-р хороо, Нэгдсэн Үндэстний гудамж-5 Улаанбаатар-15160

 <https://www.facebook.com/jicadpub1and2>

 <https://www.jica.go.jp/project/mongolian/mongolia/030/index.html>

